



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/2/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.20 № 2/22

танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН Г
ТАМГЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Х.БАТ-ОРГИЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519056

E:\ajil\2019 он\СТА 2018\3.Shuuhim TG\4. tailagnal\Аудитын гэрчилгээ-Шүүх.docx

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Шүүхийн тамгын газрын дарга Х.Бат-Оргилд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Б. Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдрийн 16/03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газар нь Хүний эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтооно. Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндсэн хуульд байгууллагыг хамгаалах, хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Шүүх байгуулах тухай хуулиар Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Захиргааны хэргийн анхан шатны шүүх

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Шүүгчийн эрх зүйн байдлын тухай

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 2 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон ба аккруэл сууриар бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн хувьд дээрх үзүүлэлтийг суурь болгож авах нь зүйтэй гэж үзлээ.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны Нийт зардал 989912,0 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 19,798.24 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдлийн түвшинтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	6.80	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	6.80	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 889,1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 891.4 мянган төгрөг буюу 99,1 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 3.1 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 2.3 сая, ажил олгогчоос олгосон нийгмийн даатгалын шимтгэл 1.9 сая төгрөг тус тус хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд мэдээлбэл зохих 25 мэдээ, 7 хоногийн дотор мэдээлбэл зохих 1158.7 сая төгрөгийн 21 гүйлгээг цахим сайтад хугацаанд нь бүрэн байршуулжээ.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлант хугацаанд цалинтай холбоотой авлага үүсгэсэн.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8-т заасан "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид батлагдсан төсвийг чанд мөрдөж өр авлагагүй ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Саналгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019.04.25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,581,691.12</u>	<u>34,812,344.55</u>
33	АВЛАГА	63,517.12	6,802,270.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	63,517.12	1,000,000.00
335	Бусад авлага	00.00	5,802,270.55
3351	Байгууллагаас авах авлага	00.00	5,802,270.55
35	БАРАА МАТЕРИАЛ	25,518,174.00	28,010,074.00
354	Хангамжийн материал	25,518,174.00	28,010,074.00
35410	Бичиг хэргийн материал	3,294,336.00	3,961,596.00
35420	Аж ахуйн материал	20,898,538.00	21,728,178.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	995,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,325,300.00	1,325,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>596,650,839.88</u>	<u>575,165,570.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	596,650,839.88	575,165,570.93
392	Биет хөрөнгө	596,346,139.88	512,421,820.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	635,584,700.00	488,335,355.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	-122,114,977.74	-32,786,082.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,606,000.00	78,936,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-82,332,666.89	-75,936,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	139,249,281.01	146,078,901.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-104,758,445.83	-127,825,298.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,018,235.12	84,413,235.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,994,485.79	-51,491,990.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	189,400.00
39217	Ном	2,088,500.00	2,508,300.00
393	Биет бус хөрөнгө	304,700.00	62,743,749.96
39301	Програм хангамж	891,000.00	891,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-586,300.00	-668,250.04
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	62,521,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>622,232,531.00</u>	<u>609,977,915.48</u>
413	Өглөг	63,517.12	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	63,517.12	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>622,169,013.88</u>	<u>609,977,915.48</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	622,169,013.88	609,977,915.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	756,199,719.00	818,720,719.00
51101	Өмч: - төрийн	756,199,719.00	818,720,719.00
512	Хуримтлагдсан үр дүн	-170,257,495.77	-247,354,994.28
51210	Өмнөх үеийн үр дүн	-170,257,495.77	-170,257,495.77
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-77,097,498.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	36,226,790.65	38,612,190.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>622,232,531.00</u>	<u>609,977,915.48</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	901,025,443.22	912,814,500.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,675,843.22	11,718,800.49
120	Нийтлэг татварын бус орлого	12,675,843.22	11,718,800.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,675,843.22	11,718,800.49
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	455,920.49
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,675,843.22	11,262,880.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	888,349,600.00	901,095,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	888,349,600.00	899,095,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	888,349,600.00	899,095,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	946,834,098.55	934,530,178.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	946,834,098.55	934,530,178.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	932,927,395.55	926,329,284.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	700,171,718.00	678,037,083.45
210101	Үндсэн цалин	661,342,797.00	596,598,410.45
210102	Нэмэгдэл	00.00	45,523,583.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,608,000.00	18,077,100.00
210104	Урамшуулал	13,220,921.00	17,837,990.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,472,245.21	80,777,990.49
210201	Тэтгэврийн даатгал	48,136,862.21	50,571,527.69
210202	Тэтгэмжийн даатгал	5,903,971.00	7,859,325.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,311,203.00	6,306,219.45
210204	Ажилгүйдлийн даатгал	1,382,734.00	1,413,698.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,737,475.00	14,627,220.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,715,693.00	42,921,263.00
210301	Гэрэл, цахилгаан	3,561,227.00	5,294,414.00
210302	Түлш, халаалт	32,844,706.00	34,991,119.00
210303	Цэвэр, бохир ус	2,309,760.00	2,635,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,428,480.00	49,300,025.00
210401	Бичиг хэрэг	11,314,470.00	12,461,930.00
210402	Тээвэр, шатахуун	12,830,000.00	15,410,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,142,390.00	11,943,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	186,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	130,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,011,620.00	9,118,295.00
2105	Нормативт зардал	725,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	725,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,740,000.00	13,598,532.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,140,000.00
210604	Урсгал засвар	10,740,000.00	12,458,532.00
2107	Томилолт, зочны зардал	7,509,900.00	8,763,100.00
210702	Дотоод албан томилолт	7,509,900.00	8,763,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,625,403.00	3,287,502.00

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	811,103.00	2,516,602.00
210803	Даатгалын үйлчилгээ	660,000.00	660,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,300.00	88,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	55,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,538,956.34	49,643,788.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	515,300.00	1,999,820.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,023,656.34	47,643,968.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,906,703.00	8,200,894.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,968,190.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,468,190.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,500,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,938,513.00	8,200,894.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,938,513.00	8,200,894.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-45,808,655.33	-21,715,677.56
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	55,381,820.95
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	55,381,820.95
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-55,381,820.95
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-45,808,655.33	-77,097,498.51

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	890,817,790.00	912,508,205.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	890,817,790.00	912,508,205.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	888,349,600.00	899,095,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	888,349,600.00	899,095,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,468,190.00	11,412,505.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,468,190.00	11,412,505.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	890,817,790.00	906,596,205.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	890,817,790.00	906,596,205.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	876,911,087.00	886,982,806.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	700,573,948.00	684,839,354.00
210101	Үндсэн цалин	661,684,797.00	562,505,574.00
210102	Нэмэгдэл	00.00	80,247,012.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,608,000.00	24,287,100.00
210104	Урамшуулал	13,281,151.00	17,799,668.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,478,663.00	80,322,070.00
210201	Тэтгэврийн даатгал	49,059,897.00	53,617,607.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,888,857.00	6,976,820.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,929,080.00	5,746,921.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,376,616.00	1,265,343.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,224,213.00	12,715,379.00

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,688,193.00	42,921,263.00
210301	Гэрэл, цахилгаан	3,561,227.00	4,264,414.00
210302	Түлш, халаалт	32,832,206.00	36,021,119.00
210303	Цэвэр, бохир ус	2,294,760.00	2,635,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,459,980.00	45,550,665.00
210401	Бичиг хэрэг	11,656,240.00	12,335,900.00
210402	Тээвэр, шатахуун	12,850,000.00	16,405,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,285,390.00	11,943,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	186,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	145,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,523,350.00	4,499,965.00
2105	Нормативт зардал	800,000.00	798,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	798,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	18,500,332.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,395,500.00	3,751,000.00
210604	Урсгал засвар	10,604,500.00	14,749,332.00
2107	Томилот, зочны зардал	7,509,900.00	8,763,100.00
210702	Дотоод албан томилот	7,509,900.00	8,763,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,900,403.00	3,287,502.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	811,103.00	2,516,602.00
210803	Даатгалын үйлчилгээ	660,000.00	660,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,300.00	88,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	1,999,820.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	1,999,820.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,906,703.00	19,613,399.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,968,190.00	11,412,505.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,468,190.00	11,412,505.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,500,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,938,513.00	8,200,894.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,938,513.00	8,200,894.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	5,912,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	5,912,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	5,912,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	5,912,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	5,912,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-5,912,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	756,199,719.00	36,226,790.65	-170,257,495.77	00.00	622,169,013.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	756,199,719.00	36,226,790.65	-170,257,495.77	00.00	622,169,013.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	2,385,400.11	00.00	00.00	2,385,400.11
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	62,521,000.00	00.00	00.00	00.00	62,521,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-77,097,498.51	00.00	-77,097,498.51
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-247,354,994.28	00.00	609,977,915.48

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	779,298,600.00	824,551,168.00	899,095,700.00	890,894,806.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	779,298,600.00	824,551,168.00	899,095,700.00	890,894,806.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	776,805,600.00	822,058,168.00	896,795,700.00	890,894,806.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	616,267,000.00	615,924,989.00	684,840,200.00	684,839,354.00
210101	Үндсэн цалин	579,818,700.00	578,955,903.00	561,857,200.00	562,505,574.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	85,642,000.00	80,247,012.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,634,400.00	20,165,500.00	24,942,000.00	24,287,100.00
210104	Урамшуулал	16,813,900.00	16,803,586.00	12,399,000.00	17,799,668.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,789,300.00	115,545,957.00	82,181,000.00	80,322,070.00
210201	Тэтгэврийн даатгал	43,220,296.00	41,949,411.00	53,540,400.00	53,617,607.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,868,973.00	4,588,219.00	7,160,200.00	6,976,820.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,142,151.00	55,899,138.00	5,728,100.00	5,746,921.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,273,478.00	1,310,918.00	1,432,100.00	1,265,343.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,284,402.00	11,798,271.00	14,320,200.00	12,715,379.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,361,100.00	36,361,100.00	43,299,800.00	42,921,263.00
210301	Гэрэл, цахилгаан	3,416,000.00	4,409,868.00	4,275,900.00	4,264,414.00
210302	Түлш, халаалт	29,155,100.00	30,449,634.00	36,023,900.00	36,021,119.00
210303	Цэвэр, бохир ус	3,790,000.00	1,501,598.00	3,000,000.00	2,635,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,762,800.00	33,720,722.00	45,964,200.00	46,068,665.00

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	8,082,300.00	8,930,710.00	12,335,900.00	12,280,900.00
210402	Тээвэр, шатахуун	12,868,200.00	11,924,200.00	16,405,300.00	16,405,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,880,100.00	9,878,862.00	11,943,000.00	11,943,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	600,000.00	599,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	129,900.00	126,000.00	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,802,300.00	2,860,950.00	4,500,000.00	4,659,965.00
2105	Нормативт зардал	400,000.00	300,000.00	800,000.00	798,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	300,000.00	800,000.00	798,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,649,100.00	12,000,000.00	23,000,000.00	22,894,332.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	7,000,000.00	7,055,000.00
210604	Урсгал засвар	10,649,100.00	9,000,000.00	16,000,000.00	15,839,332.00
2107	Томилолт, зочны зардал	5,791,400.00	5,771,300.00	9,284,300.00	8,763,100.00
210702	Дотоод албан томилолт	5,791,400.00	5,771,300.00	9,284,300.00	8,763,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,784,900.00	2,434,100.00	5,426,200.00	2,287,502.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,268,100.00	1,003,500.00	4,571,100.00	1,516,602.00
210803	Даатгалын үйлчилгээ	666,800.00	666,800.00	660,100.00	660,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	260,000.00	192,800.00	165,000.00	88,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	11,000.00	30,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	560,000.00	560,000.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	2000000.00	1999820.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	2,000,000.00	1,999,820.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2493000.00	2493000.00	2300000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,493,000.00	2,493,000.00	2,300,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,493,000.00	2,493,000.00	2,300,000.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	779,298,600.00	774,551,168.00	899,095,700.00	890,894,806.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	779,298,600.00	774,551,168.00	899,095,700.00	890,894,806.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	779,298,600.00	774,551,168.00	899,095,700.00	890,894,806.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36.00	37.00	38.00	38.00
620001	Удирдах ажилтан	04.00	05.00	05.00	05.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00	29.00	29.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	04.00	04.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	35.00	37.00	38.00	38.00
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	16.00	16.00	16.00	17.00
650002	Терийн тусгай албан хаагч (ТТ)	09.00	11.00	12.00	11.00
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	10.00	10.00